

Япон Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр /Япон хэл, Япон соёл судлаач оюутан болон ЕБС-ийн багшийн мэргэжил дээшлүүлэх курс/

2021 оны Японы санхүүгийн жилд хэрэгжих Япон Улсын Засгийн газар (Япон улсын Боловсрол, шинжлэх ухааны яам)-ын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж шалгалт өгөх хүсэлтэй монгол оюутнуудыг дараах шаардлагын дагуу бүртгэж байна.

Харин шинэ төрлийн корона вирусийн тархалтын нөхцөл байдлаас хамаарч бүртгэл болон сонгон шалгаруулалтыг зогсоох тохиолдол гарах магадлалтай тул тус нөхцөл байдлыг ойлгосны үндсэн дээр бүртгэлд хамрагдахыг хүсье.

1. Хөтөлбөрийн танилцуулга

Япон хэл, Япон соёл судлаач оюутан

Япон Улсын их дээд сургуульд япон хэлний мэдлэг, Япон орон болон Японы соёлын талаарх мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор Япон хэл, Япон соёлын чиглэлээр суралцаж буй оюутнуудад зориулсан хөтөлбөр болно.

2021 оны 10 дугаар сараас Японы их дээд сургуульд Япон хэл, Япон соёл судлаач оюутнаар нэг жилийн хугацаанд суралцах бөгөөд уг хугацааг сунгах боломжгүй. Суралцах хугацаанд сар бүр 117,000 иенийн тэтгэлэг олгогдоно.

ЕБС-ийн Багшийн мэргэжил дээшлүүлэх курс

ЕБС-ийн үндсэн багш нарт зориулсан Япон улсын их, дээд сургуульд “Сургуулийн боловсрол” той холбоотой судалгаа хийх хөтөлбөр болно.

2021 оны 10 дугаар сараас 2023 оны 3 дугаар сар хүртэл Япон талаас хуваарилсан их дээд сургуулийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах ба тогтсон хугацааг сунгах боломжгүй. Суралцах хугацаанд сар бүр 143,000 иенийн тэтгэлэг олгогдоно.

2. Тавигдах шаардлага, болзол

※Дээрх 2 хөтөлбөрт адилхан тавигдах шаардлагыг [Энд](#) дарж үзнэ үү.

Япон хэл, Япон соёл судлаач оюутан

1. 1991 оны 4 дүгээр сарын 2-ноос 2003 оны 4 дүгээр сарын 1-ний хооронд төрсөн байх.
2. Монгол улсын их, дээд сургуулийн 2 эсвэл 3 дугаар курсын оюутан бөгөөд үндсэн мэргэжил нь Япон хэл, Япон соёл байх /2 дахь гадаад хэл, дагалдах мэргэжлийн хүрээнд япон хэл, япон соёл үзэж байгаа бол энэ шалгалтыг өгөх боломжгүй. Мөн бүртгэлийн үеэр их сургуульд харьяалалтай боловч чөлөө авсан оюутнуудын хувьд шалгалтанд оролцох эрхгүй болно/.
3. Япон улсын их, дээд сургуульд япон хэлээр суралцахад хангалттай япон хэлний мэдлэг чадвартай байх.

ЕБС-ийн Багшийн мэргэжил дээшлүүлэх курс

1. 1986 оны 4 дүгээр сарын 2-ноос хойш төрсөн байх.
2. Их дээд сургууль эсвэл багшийн сургууль төгссөн байх.
3. Монгол улсын ЕБС-д одоо үндсэн багшаар багшилж байгаа бөгөөд 2021 оны 10 дүгээр сарын 1-ний байдлаар үндсэн багшаар 5 ба түүнээс дээш жил багшилсан туршлагатай байх (Их, дээд сургуулийн багш, цагийн багш, ЕБС-ийн удирдах ажилтан, япон ба англи хэлнээс бусад гадаад хэлний багшийн хувьд оролцох боломжгүй).
4. Япон хэлийг идэвхтэй сурах хүсэлтэй байх. Япон орныг сонирхдог бөгөөд Японд очсон хойноо өөрийн зүгээс идэвх санаачлага гарган Япон орны тухай ойлголтоо гүнзгийрүүлэх хүсэлтэй байх. Мөн Японд судалгааны ажилд оролцож, Японд амьдрах чадвартай байх.

Бусад мэдээллийг доорх хуудсаар орж авна уу.

[Course Guide of JAPANESE STUDIES PROGRAM 2021](#)

[Course Guide of TEACHER TRAINING STUDENTS PROGRAM 2021](#)

3. Бүртгэл

Тус хөтөлбөрийн нөхцөл, шаардлагыг сайтар уншиж танилцсаны үндсэн дээр шаардлага хангах материалыг бүрдүүлж доорх имэйл хаягаар бүртгүүлнэ үү.

Хэзээ: 2021 оны 1 дүгээр сарын 27(лхагва гараг)- наас 29 (баасан гараг) -ний өдрүүдэд имэйл хаягаар бүртгэлийн материалыг хүлээж авна.

Бүртгэлийн материал илгээх имэйл хаяг: jscholarship1@ul.mofa.go.jp

Анхааруулга

Бүртгэлийн материалыг тус ЭСЯ хүлээн авсан тохиолдолд заавал хариу имэйл илгээх болно. Хариу имэйл ирэхгүй тохиолдолд ЭСЯ-ны Соёл, мэдээллийн хэлтэс (утас: 11-320777, дотуур дугаар 124, 125) рүү холбоо барьна уу.

Бүрдүүлэх бичиг баримт

Япон хэл, япон соёл судлаач оюутан

Хөтөлбөрийн нэр: Япон хэл, япон соёл судлаач оюутан

Гол хэсэгт: Өөрийн овог нэр, утасны дугаараа бичих

1. Сургуулийн тодорхойлолт (Элссэн он болон одоо хэддүгээр курсэд суралцаж буйг тэмдэглэсэн байх)
2. Дүнгийн тодорхойлолт
3. Иргэний үнэмлэхний хуулбар
4. Япон хэлний түвшин тогтоох шалгалтын оноо байгаа тохиолдолд илгээх
5. Цээж зураг

ЕБС-ийн Багшийн мэргэжил дээшлүүлэх курс

Хөтөлбөрийн нэр: ЕБС-ийн Багшийн мэргэжил дээшлүүлэх курс

Гол хэсэгт: Өөрийн овог нэр, утасны дугаараа бичих

1. Ажлын газрын тодорхойлолт (5 ба түүнээс дээш жил үндсэн багшаар ажиллаж буйг баталсан)
2. Төгссөн их сургуулийн дипломны хуулбар
3. Япон хэлний түвшин тогтоох шалгалтын оноо эсвэл ТОЕФЛ-ийн оноо байгаа тохиолдолд илгээх
4. Япон Улсад мэргэжил дээшлүүлж ирсний дараа ажилдаа эргэн орж, ажиллахыг нотолсон тодорхойлолт. (Тодорхойлолт авах хүндрэлтэй тохиолдолд тус хэлтэс рүү холбогдоно уу)
5. Цээж зураг

Шалгаруулалт

Ярилцлагын шалгалт:

Бичиг баримтын шалгаруулалтанд тэнцсэн тохиолдолд ярилцлагын шалгалт авна.

(zoom ашиглаж, ярилцлага авна)

Ярилцлагын өдөр, цаг болон ямар аргаар хийх талаар бичиг баримтын шалгаруулалтанд тэнцсэн хүмүүст мэдэгдэнэ.

Бичгийн шалгалт:

Ярилцлагын шалгалтанд тэнцсэн тохиолдолд бичгийн шалгалт авна.

Япон хэл, соёл судлаач оюутан хөтөлбөр: Япон хэл

Багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр: Япон хэл, Англи хэл

Бичгийн шалгалт авах өдөр, цаг, газар:

Ярилцлагын шалгалтанд тэнцсэн хүмүүст Японы ЭСЯ-наас холбоо барьна.

Харин шинэ төрлийн корона вирусийн улмаас шалгалт авах боломжгүй тохиолдол гарч болзошгүй.

※Ярилцлагын шалгалтанд тэнцсэн гэдэг нь хамгийн эцсийн хариу биш бөгөөд Япон Улсын БСШУСЯ-аас эцсийн хариуг 7 сард зарлана.

Асуулт хариултын хэсэг

Жил бүр хамгийн их асуудаг асуултуудад дараахийн дагуу хариулт өгч байна. Доорх асуултаас гадна лавлах зүйлс байвал Японы ЭСЯ-ны Соёл, мэдээллийн хэлтэс (утас: 11-320777) рүү холбоо барьна уу.

Q1: Өнгөрсөн жилийн шалгалтын асуултыг харах боломж байдаг уу?

⇒Тус 2 хөтөлбөрийн өнгөрсөн жилийн шалгалтын асуултыг харах боломжгүй. Засгийн газрын тэтгэлэгт бусад хөтөлбөрийн шалгалтын асуултыг [энэ линкээр](#) орж харах боломжтой.

Q2: Япон хэл, англи хэлний шалгалтын түвшин ямар зэрэгт байдаг вэ?

⇒Шалгалт өгөх эрх бүхий шаардлагатай япон хэл, англи хэлний түвшиний талаар (2. Тавигдах шаардлага, нөхцөл)-ийг харна уу. Бичгийн шалгалтын оноогоор дэлхийн бусад орны шалгалт өгч буй хүмүүсийн оноотой харьцуулж шийддэг болно.

Q3: Япон хэл огт мэдэхгүй бол ЕБС-ийн Багшийн мэргэжил дээшлүүлэх курст хамрагдаж болох уу?

⇒ Болно. Бичгийн шалгалтанд англи хэл, япон хэлний аль өндөр оноо авснаар шийдвэр гардаг. Харин японд амьдрахад шаардлагатай япон хэлний мэдлэгтэй бол үнэлгээ нэмэгдэх тул япон хэлний шалгалтын хуудсыг бөглөхийг хүсье.

“Тавигдах нөхцөл, эцсийн сонгон шалгаруулалтын талаар”

Q4: Японы Засгийн газрын тэтгэлэгт шалгалтын ярилцлагын шалгалтанд тэнцсэн байтал 7 сард тэнцээгүй гэсэн хариу ирсэн. Бичгийн шалгалт, ярилцлагын шалгалтанд тэнцсэн байхад яагаад тэнцээгүй гэсэн хариу ирдэг юм бэ?

⇒ Бичгийн шалгалт, ярилцлагын шалгалтанд тэнцсэн оюутанг тус Элчин сайдын яам Японы Боловсрол, Шинжлэх ухааны яамд нэр дэвшүүлдэг. Түүний дараа Японы Боловсрол, Шинжлэх ухааны яам дахин сонгон шалгаруулалт явуулж эцсийн хариуг гаргадаг. Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт элсүүлэх шалгалт Монголд төдийгүй дэлхийн бүх орнуудад зохион байгуулагддаг ба дэлхийн бусад орнуудаас нэр дэвшигдсэн нийт оюутнууд дундаас сонгон шалгаруулдаг тул Монгол дахь сонгон шалгаруулалтанд тэнцлээ гээд Японд суралцах боллоо гэсэн үг биш юм.

Лавлах: Япон Улсын Элчин сайдын яам Соёл, мэдээллийн хэлтэс
Имэйл хаяг: public.diplomacy-section@ul.mofa.go.jp
Утас: 11-320777 (дотуур утас 124, 125)